

ДАЯАРШЛЫН ҮЕИЙН МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН ДИПЛОМАТ БОДЛОГО

*МУИС, ОУХС-ийн
ахлах багш Л.Даваадэлгэр*

Өнөө үед дэлхийн улс төр, эдийн засгийн үйл ажиллагаа улам бүр хамааралтай болж дотоод бодлого, зорилтыг хэрэгжүүлэхэд гадаад хүчин зүйл улам их нөлөөлөх боллоо. Глобальчлах үйл явц дэлхийн улс орнуудын өмнө эдийн засгийн гадаад харилцааг өргөтгөн хөгжүүлэх ихээхэн бололцоо нээж эгэхийн сацуу дэлхийн зах зээлийн төлөөх тэмцлийг хөөрөгдөн хурцатгаж эдийн засгийн дипломатын хэлбэр болох гадаадын шууд хөрөнгө оруулалт, экспортыг хөхүүлэн дэмжих, өрийн асуудал, олон улсын олон талт хэлэлцээрт нэгдэн орох ажиллагаа зэргийг улам нарийн явуулахыг шаардаж байна. Худалдаа эдийн засгийн харилцаа нь улс хоорондын хэлхээ холбооны үндсэн бүрэлдэхүүн, материаллаг суурь нь болж байдаг. Ийм харилцаа сайн нөхөрлөлийг бэхжүүлдэг хамгийн бат сэжим болдог гэж нийтээр үздэг. Тухайн орны нийгэм эдийн засгийн хөгжлийн хэрэгцээ нь түүний дипломат ажиллагааны агуулга, зорилго, чиглэлийг тодорхойлох гол хүчин зүйл болдог. Худалдаа эдийн засгийн харилцаа нь улс төрийн хамтын ажиллагааны замыг засаж түүний шинж чанарт нөлөөлдөг. Эдийн засгийн хөгжлийн тэгш бус байдлыг бүх бололцоогоор багасгаж гэтлэн давах арга замыг олоход дөхөм үзүүлэх нь эдийн засгийн дипломат ажиллагааны нэг гол зорилт болж байна.

Глобальчлалын үйл явц нэгдэн нийлж хамтран ажиллаж, хөгжиж дэвжихийн сайн зүйл авчрахын хэрээр саар зүйл дагуулах ч бий. Глобальчлалын үед тодорхой улс орны бүрэн эрхт байдал, улсын хил хязгаарын асуудал зарим утгаараа хөндөгддөг билээ. Нэгдэх үйл явцад шилжсэнээр урьд нь тухайн орны дотоод хэрэг гэж тооцогддог байсан зүйлс өнөөгийн нөхцөлд хувьсан өөрчлөгдөж өөр орны ашиг сонирхлыг хөнддөг болсон ба эндээс харилцан үл ойлголцох байдал, зөрчил тэмцлийг бий болгодог. Глобальчлалын явцад жижиг орны аюулгүй байдлын асуудал ихээр хөндөгддөг /ялангуяа эдийн засгийн аюулгүй байдал/ бөгөөд Монгол улс буурай орны хувьд маш идэвхтэй хамтран ажиллахын сацуугаар өөрийн улс үндэстний аюулгүй байдал, бүрэн эрхт байдлаа хангах, хадгалахын тулд бодлогоо зөв тодорхойлж энэ үйл явцад хэрхэн оролцох, юу хожихоо урьдчилан тогтоох зүй ёсны шаардлага тулгарч байна.

Өнөөгийн дэлхийн аж ахуйн нөхцөл байдал XIX зууны Европын улсуудын тухайн үеийн хийгээд АНУ-ын ерөнхийлөгч Тафтын долларын дипломат бодлогын байдалтай ихэд төстэй агаад нэг талаас глобальчлалын үйл явц нэн ялангуяа технологийн дэвшил, санхүү, эдийн засгийн харилцан хамаарал дэлхий ертөнцийг улам нэгтгэн давчуу

болгож байна. Энэ үйл явц гэнэт хаа нэгтээгээс гараад ирээгүй харин түүхэн хөгжлийн үргэлжлэл мөн.

800 -гаад жилийн тэртээ дэлхийн талыг эзэлсэн Чингисийн эзэнт гүрнээс улбаатай энэхүү үйл явц нь буурал түүхийн явцад хувьсан өөрчлөгдөж өнөөгийн төрхөө олжээ. Эзэнт гүрний эдийн засгийн харилцааны асуудлуудыг гагцхүү “Монголын нууц товчоо”-той холбон үзэж, гол агуулгыг тэндээс эрэх нь зөв болов уу. Учир нь Монголын нууц товчоо бол чухамхүү Чингисийн үеийн Монголын нийгмийн амьдралын “нөлөөгүй толь” билээ. Бидний авч үзэж буй асуудлын талаар МНТ-ны мэдээлэл чамлахааргүй ажээ. МНТ хамарч буй түүхэн цаг үеийнхээ Монголын нийгмийн харилцааны бодит дүр төрхийг бүх талаас нь хувьсал хөдөлгөөн дунд нь, хамгийн ерөнхий төлөвөөр нь харуулсан агаад нийгмийн амьдралын аль нэг талыг онцгойлсон буюу орхигдуулсан зүйл үгүй мэт. Тэнд хэдийгээр эдийн засгийн тодорхой асуудлыг жич хөндөөгүй ч агуулга нь бидэнд зохих мэдээллийг өгдөг.

Чингис хааны эдийн засгийн бодлого бол Монгол улсын төрийн тусгаар тогтнолын үндсийг бэхжүүлэх, аливаа улс орноос ямар нэг талаар буюу хэмжээгээр хараат байх явдлыг үл гаргах, тийм байдлын шалтгаан үндсийг арилгах, үндэсний эдийн засгийн бие даасан байдлыг найдвартай хангаж баталгаажуулах явдал байв.

Монгол улсын тусгаар тогтнол эцсийн дүнд эдийн засгийн хүчин чадлын өсөлтөөр баталгаажих учиртайг тэрээр сайн ойлгож байв. Түүний гадаад бодлогын учир утга ч тэр л зарчим, сонирхолд үндэслэж байв. Тухайн үеийн жишээг авч үзье л дээ. Чингис хааны хувьд Монгол улсын бат бэх байдлыг бэхжүүлэх, улс төр, эдийн засгийн талаар Зүрчидийн Алтан улсын хараанаас гарах явдал маш чухал байж. Учир нь Монгол улс жил бүр Алтан улсад мянган лан алтаар алба барьж байсан байна. Алтан улс монголчуудыг Хятадтай харилцах, худалдаа, наймаа хийхийг хавчин боож байв. Тиймээс Монгол, Хятадын хооронд байсаар ирсэн худалдаа, эдийн засгийн харилцааг үл тасалдуулах, улмаар Монголд ашигтайгаар шийдвэрлэх, Хятадтай ямар нэг хориг саадгүй, арилжаа солилцоо тогтмол хийх нөхцлийг бий болгох хэрэгтэй байв. Өөрөөр хэлбэл Алтан улсын нөлөөг устган улмаар умард Хятадыг нөлөөндөө оруулахыг эрмэлзэж байжээ. Гэхдээ үүнд ихээхэн цаг хугацаа орохыг ойлгож байсан тул өөр бусад улс орон тухайлбал Дундад Азийхантай худалдааны харилцааг өргөтгөж, бүдгэрч үгүй болох шахсан их торгон замыг сэргээсэн билээ.

Хожим Өгөөдэй хаан Алтан улсыг номхотгон дарснаар их хааны зорилгыг гүйцэлдүүлж Монгол улсын халдашгүй дархан байдал, эдийн засгийн тогтворжин хөгжих нөхцлийг бүрдүүлсэн. Түүхийн бусад бүтээл туурвилуудаас тунгаан эрэгцүүлбэл Чингис хааны байгуулсан эзэнт гүрний эдийн засгийн бүтцийг дараахи байдлаар тодорхойлж болохоор байгаа юм. Үүнд:

- Мал аж ахуй, газар тариалан;
- Байгаль орчныг хайрлан хамгаалах, зүй зохисыг хангах;
- Дотоод, гадаад худалдаа, түүнийг өргөтгөх чиглэл;

- Эдийн засгийн суурь бүтэц /одоогоор дэд бүтэц/-ийг хөгжүүлэх;
- Төрийн санхүү, татварын тогтолцоог журамлах;
- Эрдэм мэдлэг, авъяас чадвар /ноу хау/, техник технологийн дэвшлийг аж ахуйн үйл ажиллагаанд өргөн ашиглах зэрэг болно.

Дэлхийн эдийн засгийн салбарт болж буй өнөөгийн глобаль үйл явцыг өөрийн эрхгүй санагдуулж байгаа юм.

Чингис хаан эдийн засгийн том бодлоготон байсан гэдгийн хувьд энэ нь түүнийг хүн төрөлхтний хоёр дахь мянганы хамгийн суут алдартнаар тодруулсан “Вашингтон пост” сонины үнэлэлтээр нотлогдож байгаа билээ. Тэнд өгүүлэхдээ Чингис хаан болон түүний залгамжлагчид Евразийг хамарсан чөлөөт худалдааны асар уудам бүс бүрэлдүүлж, өрнө дорнын соёл иргэншлийн хэлхээ холбоог бэхжүүлж өгсөн юм. Үүнийг дундад зууны үеийн ГАТТ-ын тогтолцоо байсан гэж хэлж болно. Тэд интернет бүтээхээс 700 жилийн өмнө дэлхийг холбосон харилцаа холбооны сүлжээг анх бий болгосон байна. XIII зууны дунд үед Монголын нэгдсэн улс дотоод гадаад худалдааны бүхэл бүтэн тогтолцоотой болоод байжээ. Улс орны эдийн засгийн хөгжилд чухал нөлөө бүхий худалдаа төрийн хуулийн хамгаалалттай байсан цагт зохих үр дүнд хүрдэг нь зүй. Чингис хаан болон түүний залгамжлагчдын үед энэ шаардлага хангагдаж байсан болохсор өрнө, дорнын орнууд Монголтой худалдаа хийх сонирхолтой байв. Тэр үед Хятад болон бусад суурин иргэдээс өдөр тутмын хэрэгцээт бараа таваарыг олж авах сонирхол Монголын талд их байсан бол Монголын талын түүхий эдийг олж авах сонирхол нөгөө талд амин хэрэгцээ болж байв. Ийм байдалд Их Монгол улсын эхэн үед давын өмнө бүтээгдэхүүнийг бүтээгдэхүүнээр солих байдлаар гадаад оронтой худалдаа наймаа хийж байв.

Их засаг хуулинд улс хоорондын арилжаа худалдааг хамгаалах тухай заажээ. Үнэндээ ертөнцийн баруун, зүүн хоёрыг дамнасан байгаль цаг уурын эрс ялгаатай олон сар жилийн бэрхийг туулан худалдаа наймаа хийдэг тэр цагт түүнд оролцогчдыг хамгаалж, худалдаачдыг төрийн элч, төлөөлөгчдийн зиндаанд үзэж байсан нь эдийн засгийн төдийгүй улс төрийн холч бодлогын илрэл мөн. Ийм арга хэмжээ нь Их Монголын эдийн засгийг богино хугацаанд тэнхрүүлж өөд татсан юм.

Их Монголын гадаад худалдаа ийнхүү өргөжиж буйг дагалдан дорно, өрнийг холбосон торгон замын худалдаа өргөжиж Монгол нутгаас тэмээн жингийн цуваа зүг зүгт явж тэр дотроо Дорнод Туркистан, Дундад Азид чиглэх нь их болов. Нэгэн зэрэг Чингис хаан гаднаас ирэх худалдаачдад худалдааны таатай нөхцөл үзүүлж Монголд ирж худалдаа эрхлэхийг зүйл бүрээр дэмжиж байв.

Их Монгол улсын гадаад худалдааны төв нь Хархорум хот бөгөөд Ази, Европ алс өрнө, дорнын аян жингийн хөсгийн харгуй замуудын уулзвар болж байжээ. Францын түүхч Д.Оссон Монголын эзэнт улсын төв Хархорум хот Өгөөдэй, Гүег хаадын үед өрнө, дорнын худалдааны

өнгөтэй "алтан аяга" байлаа хэмээн өгүүлсэн ажээ. Энэ бүхнээс үндэслэн глобальчлах эхний үйл явц эндээс эх авчээ гэж хэлж болно.

Гэсэн хэдий ч өнөөгийн ертөнцдөө эргэн ирвэл бараа таваар, үйлчилгээ, капитал, ажиллах хүчин ямар ч хил хязгааргүй харилцан солилцож өнөөдөр Улаанбаатар, Бээжин, Лондон, Нью-Йоркт ноолуурын үнэ ямар байна гэдгийг байнга бие биедээ мэдээлж байна. Дэлхийн нэгдмэл зах зээл буй болоод сая сая хүмүүс, мянга мянган үйлдвэр, аж ахуйн нэгж ямар ч төвлөрсөн төлөвлөгөөгүй нэг нэгийнхээ хэрэгцээ, шаардлагыг хангаж байна. Бүс нутаг, орон хүн хүнийхээ эсрэг өрсөлдөж байна. Америкийн түүхч Палмер, Колтон нарын хэлсэнчлэн XIX зууны сүүлч үед дэлхийн аж ахуй нэгдсэн зохицуулалтгүй, пүүс, компани хоорондоо үнийн зохицуулалт хийх зорилгоор картель, трест байгуулж байсантай өнөөгийн дэлхийн эдийн засаг ямар нэгэн байдлаар ижил төстэй байна. Пүүс компаниуд дэлхийн зах зээл дээр өөрийн байр сууриа олж авах гэж авсан нэг нь түүнийгээ хадгалж үлдэхээр засгийн газартаа улам их хандах болжээ. Дэлхийн II дайнаас хойш Бреттон Вудсын мөнгө санхүүгийн механизм, 50-иад оноос АНУ-ын улс төр, эдийн засгийн ноёрхол тогтож, Европын хамтын нийгэмлэг буй болон олон улсын худалдаа эдийн засгийн харилцааг хянан зохицуулж ирсэн билээ. 80-аад оны дундаас эдийн засгийн зах зээл маш их өрсөлдөөнтэй болж үлгэрлэвэл хүчтэй нь хүчгүйгээ барьдаг бичигдээгүй хууль тогтжээ.

Аливаа улсын бодит сонирхол нь эдийн засгийн ашиг шаардлагаар илэрхийлэгддэг. Глобальчлалын эрин үед дээр дурьдсан нөхцөл байдалд манайх шиг жижиг улс үндэсний ашиг сонирхлоо хэрхэн хамгаалж эдийн засгийн дипломатын чухам ямар бодлого явуулах вэ? Юуны өмнө орчин цагийн Монгол улсын дипломат бодлогын үечлэлийг авч үзье. Үүнийг үндсэндээ 4 үе шатанд хувааж болох юм.

1. 1911-1925 он
2. 1925-1960 он
3. 1960-1990 он
4. 1990-ээд оноос өнөөг хүртэл

Үүнээс үзэхэд Монгол улсын үндэсний эрх ашиг эсвэл аль нэг /хэсэг/ орны хараат байдалд эсвэл үндэсний эрх ашгаа системийн эрх ашгаар орлуулж байсан зураг харагдана. Ер нь Монголын гадаад бодлого тэр дотроо дипломат бодлого нь хэт улс төржсөн, геополитик, цэрэг, улс төрийн болон худалдаа эдийн засгийн харилцааны асуудлыг хоёрдугаар зэрэгт тавьж ирсэн ул мөр одоо ч байсаар байна. Монгол улсын гадаад харилцааг зангидан явуулах ёстой ГХЯ бүтэц, зохион байгуулалтын хувьд тогтсон механизмтай ч эдийн засгийн дипломатын бодлогыг дорвитой явуулж төдийлөн чадахгүй байна. Наад захын жишээ дурьдахад аливаа улс оронд ГЯЯ-ны төрийн нарийн бичгийн гол үүрэг нь эдийн засгийн асуудлууд хариуцдаг байхад манайд байдал өөр байна. Засгийн газрын хэмжээнд ямар оронтой, чухам ямар чиглэлээр эдийн засгийн харилцаа хөгжүүлэх талаар чиглэл баримтлал одоо хэрнээ алга. Гадаад харилцаанд хамрагдаж буй яам газруудын уялдаа зохицуулалт тааруу хэвээр байна. Төр, засгийн тэргүүний айлчлал хооронд асуудлыг боловсруулан аргацаах

жишээтэй. Эдийн засгийн дипломатын бодлогын нэгэн хэлбэр болох гадаад худалдаа, экспортыг дэмжих гадаадын шууд хөрөнгө оруулалт, өрийн асуудал, олон улсын эрх зүйн баталгаатай хамгаалалтанд багтах зэрэг асуудал мөн эдгээрт нөлөөлж буй чухам ямар хүчин зүйл байгаа талаар авч үзье.

Манай улс эдийн засгийн гадаад харилцаа түүний гол бүрэлдэхүүн хэсэг болсон гадаад худалдааг дэлхий нийтийн жишигт нийцүүлэн эрх тэгш харилцан ашигтай байх зарчимд тулгуурлан хөгжүүлэх зорилт тавин ажилласны үр дүнд зарим нэг нааштай үзүүлэлтэнд хүрсэн билээ. Ялангуяа нэг орны хамаарлаас хөндийрөн нээлттэй чөлөөт худалдааны бодлого явуулснаар гадаад худалдааны газар зүйн чиглэлд ихээхэн өөрчлөлт орж түншийн харилцаа өргөжин дэлхийн олон оронтой худалдаа хийх болов.

Зах зээлийн эдийн засагт шилжсэн өнгөрсөн хугацаанд гадаад худалдааны үйл ажиллагааг зохицуулж байсан хуучин эрх зүйн актуудыг шинэчлэхэд чухал алхам хийж цөөн тооны улсын харилцааны монополийг халж Монгол улс ДХБ-д элссэнээр манай улс худалдаа, эдийн засгийн үйл ажиллагаагаа дэлхийн глобальчлалын шаардлагаар урган гарсан эрх зүйн хэм хэмжээний дагуу явуулах боломжтой болсон. Түүнчлэн олон улсын эрх зүйн хамгаалалтанд шилжих бусад орны зүгээс үндэсний нэн тааламжтай нөхцөл бүрдүүлэх, үл ялгаварлан гадуурхах, ил тод байх, тэгш эрхийн үндсэн дээр олон улсын худалдаанд оролцож түүний давуу талыг эдлэх, татварын бодлого, тариф, тарифын бус хязгаарлалтыг олон улсын эрх зүйн шаардлагад нийцүүлэн явуулах зэрэг арга хэмжээ авч хэрэгжүүлж эхэлсэн нь гадаад худалдаанд таатай нөхцөл бүрдүүллээ. Гэвч Монгол улс энэ нөхцөл байдлыг бүрэн дүүрэн ашиглаж чадаагүй байгаа нь судалгаанаас харагдаж байна. Учир нь 1990-ээд оноос буурсаар ирсэн барааны эргэлт 1995 оноос өсч эхэлснийг тэмдэглэх хэрэгтэй. 1996 оноос хойш гадаад худалдааны төлбөрийн тэнцэл тогтмол сөрөг гарсаар байна. Гадаад худалдааны нийт эргэлтийг авч үзвэл 1990 оноос огцом буурсан ч, 1995 оноос өсч эхэлсэн нь сайшаалтай. Гэвч импорт нь экспортоос тогтмол давсаар ирсэн болохоор гадаад худалдаа үр ашигтай байсангүй. 2001 онд гадаад худалдааны нийт эргэлт 940 сая ам.доллар, түүний дотор экспорт 385.2 сая ам.доллар, импорт 554.8 сая ам.доллар болжээ. Гадаад худалдааны нийт эргэлт 2000 оныхоос 66.5 сая ам.доллараар буурч үүний дотор экспорт 47.1 сая ам.доллар буюу 13 хувь, импорт 19.4 сая ам.доллар буюу 9.7 хувь буурсан байна. Монголын гадаад худалдааны төлбөрийн тэнцэл ийнхүү алдагдалтай гарч байгаад бизнесийн гадаад, дотоод хүчин зүйл нөлөөлж байна.

Гадаад хүчин зүйлс:

- гол түнш орнууд тэдгээрийн дотор хөрш орнуудын эдийн засгийн нөхцөл байдал, валютын ханшийн өөрчлөлт, экспортын татвар, зам тээврийн тариф, хязгаарлалт зэрэг нийгэм-эдийн засгийн шинжтэй өөрчлөлтүүд;
- дэлхийн зах зээл дээрх манай экспортын гол нэрийн барааны үнийн өөрчлөлт;

- дэлхийн томоохон эдийн засгийн байгууллагуудын авч хэрэгжүүлж байгаа бодлого;

Бизнесийн дотоод орчин:

- гаалийн татвар, тарифын өөрчлөлт;
- төгрөг гадаад валютын харьцах ханш;
- дотоод дахь бусад татварын хувь хэмжээ зэрэг хүчин зүйл багтаж байна.

Гадаад худалдаа үр ашигтай байх буюу тэнцэл ашигтай гарахад импортыг бууруулах, экспортыг өсгөх шаардлагатай ч импорт нь бараа бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээгээр тодорхойлогддог учир түүнийг шууд хязгаарлах бодлого төдийлөн үр дүнгүй болох талтай. Төрөөс экспортыг дэмжих бодлого явуулахдаа экспортын дотоод бүтцийг өөрчлөх буюу анхдагч түүхий эд биш үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн гаргах замаар өсгөх нөхцөл байдлыг бүрдүүлэх нь чухал.

Дотоод зах зээлийн багтаамж бага, цөөн тооны бүтээгдэхүүн үйлдвэрлэж хэрэгцээт барааныхаа ихэнхийг гадаадаас авдаг Монгол орны хувьд экспортыг түшиглэсэн хөгжлийн загвар хамгийн тохиромжтой. Манай орны хувьд эрдэс түүхий эдийн экспорт нийт экспортод өндөр хувь эзэлж буйгаас түүхий эдэд суурилсан тогтолцоо бий болгожээ. Гадаад худалдааг үр ашигтай явуулж экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхийн тулд түүний чанарыг сайжруулах шаардлагатай. Үүний тулд техник технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлж өрсөлдөх байр суурь сегментээ зөв сонгох хэрэгтэй. Байгалийн болон амьтны гаралтай түүхий эдийн экспорт нь үндэсний баялаг бий болгох нь ховор. Монголын экспортын бүтцэд нэмэгдэл өртгийг шингээсэн үйлдвэрийн бүтээгдэхүүний эзлэх хувийн жинг аажим нэмэгдүүлэх хэрэгтэй. Дотоод, гадаад зах зээлд нийлүүлж буй бүх бараанд үндэсний стандарт нөхцлийг олон улсын жишигт нийцүүлэн тогтоож тэдгээрийг хангаагүй үйлдвэр, үйлчилгээг хязгаарлах, зогсоох хүртэл арга хэмжээ авч байх нь эдийн засгийн аюулгүй байдлыг хангах, ашигтай л бол ямар ч бараа үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэх нь хамаагүй одоогийн зарим хандлагыг арилгах эдийн засгийн болон бусад хүчин зүйлийг чанаржуулах олон талын ач холбогдотой.

Манай улсын гадаад худалдааны үр ашгийг дээшлүүлэх нэг гол материаллаг нөхцөл бол экспортын үйлдвэрлэлийг эдийн засгийн дипломат бодлогын тэргүүлэх чиглэл болгон жинхэнэ ёсоор хэрэгжүүлэх явдал гэж үзэж байна. Ойрын ирээдүйд Монгол улсын экспортын тэргүүлэх чиглэлийн салбар үйлдвэрлэл, үйлчилгээг тодорхойлсон Засгийн газрын хөтөлбөр боловсруулах шаардлагатай байна. Засгийн газар дотроо үйлдвэрлэл, экспортын бодлогын шаардлага түүний гол чиглэлийн талаар нэгдсэн ойлголттой байх нь чухал. Түүгээр үл барам уг бодлогыг нийт хүн ам ойлгож дэмжсэн байх нөхцлийг Засгийн газар бүрдүүлэх ёстой. Хэтдээ бол Засгийн газраас экспортыг дэмжих биш компаниудыг бүтээгдэхүүнээ экспортод гаргахаас өөр аргагүй тийм нөхцөл байдал бий болгох хэрэгтэй.

Монголын түүхий эдийн харьцангуй давуу талд түшиглэн бүтээгдэхүүнийхээ үнэ өртөг, үзэмж дизайн, үйлдвэрлэлийн үр ашиг, маркетингийн арга техник зэрэг бусад хүчин зүйлээр өрсөлдөх чадвараа дээшлүүлэн нэмэгдүүлэх нөөц бололцоо байна. Гадаад зах зээлийн хувьд Хятад болон Оросын асар их том зах зээл дээр шууд хиллэж байгаа явдлыг газар зүйн байршлын давуу тал болгон ашиглах бололцоо байгаа юм. Монголын экспортын ихэнх бараа ялангуяа Хятадын зах зээл дээр эрэлт хэрэгцээ сайтай байгаа бөгөөд Хятадын эдийн засгийн хурд өндөр хэвээр байвал цаашид ч хэрэгцээ өсөх болно. Үүнээс гадна хамгийн сүүлийн үеийн техник технологи тоног төхөөрөмжийг тэргүүлэх чиглэлд нэвтрүүлэн сайжруулснаар экспортын бүтээгдэхүүний чанар сайжрах ба олон улсын зах зээл дээрх эрэлт хэрэгцээ нэмэгдэнэ. Мөн өрсөлдөх чадвар нь тодорхой түвшинд хадгагдах үндэслэлтэй.

Монгол улсын худалдаа, эдийн засаг хоёр хөршөөсөө үлэмж хамааралтай, худалдааны эргэлтийн зонхилох хэсэг нь энэ хоёр хөршид ногддог онцлогийг тэргүүн зэрэгт анхаарах ёстой ч хөрш зэргэлдээ хоёр орон маань бодлого зохицуулалтын өөр өөрийн өвөрмөц онцлогоос шалтгаалан глобалчлал дэлхий нийтийн эдийн засаг эрх зүйн зохицуулалтаас гадуур байгаа нь анхаарч үзэх гол хүчин зүйл бөгөөд Монгол улсын эдийн засгийн дипломат бодлогын үндсийг тодорхойлоход харгалзах нэг чухал зүйл. Эдийн засгийн дипломатын нөгөө нэг хэлбэр нь гадаадын шууд хөрөнгө оруулалт үүнийг нэмэгдүүлэх гол арга нь Монгол улсын хувьд худалдааны болон үйлдвэрлэлийн чөлөөт бүс байгуулах явдал юм. Эдийн засгийн дипломатын тэргүүн ээлжинд зайлшгүй бодолцох зүйл бол манай хоёр хөршийн асуудал юм. Хоёр хөрштэй харилцах улс төр хүмүүнлэгийн чиглэлийн харилцааны эрх зүйн үндэс шаардлагын хэмжээнд хараахан хүрч чадаагүй байна. Монгол улс жижиг орны хувьд хүчин мөхөсдөх эрх зүйн хамгаалалт дутагдахад хүрч байгаа нь нууц биш. Монголын хөдөө аж ахуйн болон аж үйлдвэрийн гаралтай зонхилох түүхий эдийн экспорт нь ОХУ-ын импортын зөвшөөрөл лицензийн тогтолцоо дотоодын татварын бодлогоос шалтгаалан зах зээлд нь нэвтрэх боломж хэрэг дээрээ хаагдмал байдаг. Лиценз татварын бодлогоос гадна зах зээлийн нээлттэй байдал гааль хилийн бүрдүүлэлтийн горим хуулийн болон хувь этгээдийн шилжилт хөдөлгөөнийг зохицуулж буй нь худалдаа үйлчилгээг либералчлах дэлхий нийтийн жишгээс ихээхэн хол байгаа нь жижиг эдийн засагтай манай орны хувьд ноцтой сөрөг нөлөө үзүүлдэг болно. БНХАУ-ын хувьд хууль тогтоомж нь зах зээлийн чиг хандлагатай ч экспорт, импортын бараа тээвэрлэх, дамжуулан өнгөрүүлэх бодит боломж хүчин чадал үнэ тарифийн бодлогын зохицуулалт зах зээлийн эрэлт хэрэгцээнд тавих шаардлага шахалт нь тэр бүр олон улсын жишигт нийцэхгүйгээс монголын экспорт, импортод сөрөг нөлөөлсөн хэвээр байна. Хоёр хөрштэй хийж байгаа худалдаа нь өнөөг хүртэл үүргийн талт шинж чанартай, олон улсын эрх зүйд бүрэн нийцсэн гэрээ хэлцлийн дагуу хариуцлага харилцан хүлээх маргаанаа зохицуулах тогтолцоо бүхий нэг үгээр хэлэхэд эрх зүйн хувьд бүрэн хамгаалалттай экспорт, импортын үйл

ажиллагаа явагдахгүй байна. Хоёр хөршийн алинтай нь ч транзит худалдааны хэлэлцээртэй ч зүйл заалтууд хэт ерөнхий далайд гарцгүй орны хувьд олон улсын эрх зүйн дагуу эдэлбэл зохих эрх давуу талыг бүрэн бодит байдлаар тусгаж чадаагүйгээс шалтгаалан Монгол улс бүрэн хязгаарлагдсан хэвээр байна. Транзит тээвэрт хяналт шалгалт бүрдүүлэлт хийх горимд тээврийн тариф үйлчилгээ дэд бүтцийн хөгжил зэрэг олон хүчин зүйлс сөргөөр нөлөөлж байна.

This report highlights unique phenomenon called globalization which appeared in the 90-ies in the world economy. Researcher analyses its components, pros and cons of the process, advantages and disadvantages of small country such as Mongolia as well as the future consequences which might occur from point of diplomacy.

Author states that in modern terms the process is "new" but in fact it is successive acceleration of the past development. It is shown in the report by drawing comparison between the Mongolian Empire of Chinggis Khan and present - day world integration. Researcher emphasizes that since establishment of the Mongolian Empire economic diplomacy has become part of the golden box policy.

Author describes traditions, modern day developments and weak sides of economic diplomacy in Mongolia which was and has to be the very heart of its foreign policy.

Report states that globalization oblige small countries like Mongolia to bundle its forces and to realize its comparative advantages.